



ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/84

Улаанбаатар хот

Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсэг, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын 2 дугаар зүйлийн 2.1, 2.4, 2.7, 2.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн “Ёс зүйн дэд хороо байгуулах тухай” А/03 дугаар тушаалд нэмэлт өөрчлөлт оруулсугай.

2.Тус газрын нийт албан хаагчдын санал хураалтаас олонхын дэмжлэг авч Ёс зүйн дэд хорооны гишүүнээр нөхөн сонгогдсон албан хаагчдыг нэгдүгээр, Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Шинээр томилогдсон гишүүдэд эрх, үүргийг танилцуулж ажиллахыг Ёс зүйн дэд хорооны дарга (Б.Одбаяр)-д үүрэг болгосугай.


4.Тушаалын хэрэгжилтийг эрх бүхий албан тушаалтанд улирал бүр танилцуулж, хяналт тавьж ажиллахыг Ёс зүйн дэд хорооны дарга (Б.Одбаяр)-д даалгасугай.

ДАРГА П. БАТБААТАР



152401000749


Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны 11 дугаар сарын 27-ны өдрийн 11/11 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**Ес зүйн дэд хорооны гишүүнээр нөхөн
сонгогдсон албан хаагч**

| Д/д | Албан тушаал | Албан хаагчийн овог, нэр |
|-----|---|--------------------------|
| 1 | Захиргаа удирдлагын газрын Хуулийн ахлах мэргэжилтэн | А.Номин |
| 2 | Чанар хяналтын газрын Ахлах мэргэжилтэн | Д.Оюунчимэг |
| 3 | Үйлчилгээний нэгдсэн төвийн зохицуулалтын газрын Нийслэл хариуцсан хэлтсийн Ахлах мэргэжилтэн | Ж.Даваасүрэн |
| 4 | Үйлчилгээний нэгдсэн төвийн зохицуулалтын газрын Төв аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн Үйлчилгээний ахлах ажилтан | Б.Довдонцэрэн |

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны 10 сарын 04-ны өдрийн 187 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн

| Д/д | Албан тушаал | Албан хаагчийн овог, нэр |
|-----|---|--------------------------|
| 1 | Систем нэгтгэл, сургалт хөгжлийн газрын дарга | Б.Одбаяр |
| 2 | Үйлчилгээний нэгдсэн төвийн зохицуулалтын газрын Завхан аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн дарга | Ц.Бямбажав |
| 3 | Захиргаа удирдлагын газрын Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, тайлан, төлөвлөгөө хариуцсан ахлах мэргэжилтэн | Н.Алтансүвд |
| 4 | Захиргаа удирдлагын газрын Хуулийн ахлах мэргэжилтэн | А.Номин |
| 5 | Чанар хяналтын газрын Ахлах мэргэжилтэн | Д.Оюунчимэг |
| 6 | Үйлчилгээний нэгдсэн төвийн зохицуулалтын газрын Нийслэл хариуцсан хэлтсийн Ахлах мэргэжилтэн | Ж.Даваасүрэн |
| 7 | Үйлчилгээний нэгдсэн төвийн зохицуулалтын газрын Төв аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн Үйлчилгээний ахлах ажилтан | Б.Довдонцэрэн |